

# 2015

ЖИЛИЙН  
ТАЙЛАН



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Даатгуулагчдынхаа эрэлт хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн, тэдний амар тайван амьдралын баталгааг хангасан, харилцагчдаа амжилтад хөтөлсөн, нийгмийн хариуцлагыг дээдлэгч, ил тод нээлттэй, итгэл төрүүлсэн тэргүүлэгч даатгагч, даатгалын үйлчилгээ үзүүлэгч болно.

## АГУУЛГА

1	ТУЗ-ийн даргын мэндчилгээ	1
2	Гүйцэтгэх захирлын илгээлт	2
3	Засаглал, бүтэц	3
4	2015 оны эдийн засгийн тойм	5
5	Даатгалын зах зээл	7
6	Даатгалын үйл ажиллагааны тайлан	8
7	Санхүүгийн гүйцэтгэл	11
8	Хүний нөөц	12
9	Нийгмийн хариуцлага, хамтын ажиллагаа	13
10	Аудитын тайлан	14





# ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт харилцагч, хамтрагч, хувьцаа эзэмшигч, ажиллагсад та бүхний энэ өдрийн мэндийг айлтгахын ялдамд та бүхэнд эрүүл энх, аз жаргал, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Ард Даатгал ХХК нь 2015 оныг амжилттай үдэж, 2016 ондоо ихийг хийж бүтээх чин эрмэлзэл дүүрэн орж байна.

Улс орны хувьд бүхлээрээ нийгэм, улстөрийн нөхцөл байдал амаргүй, эдийн засаг, бизнесийн орчин таагүй нэгэн он жилийг бид хамтдаа зүтгэж, даван тууллаа. Компанийн үйл ажиллагааг жигд авч явах, ужгирсан асуудлуудыг шийдвэрлэх, шинэ нөхцөл байдалд тохируулан хэцүү ч гэсэн гаргах ёстой шийдвэрүүдийг бид гаргаж, хамгийн хэцүү үеийг ардаа орхисон гэдэгт би итгэлтэй байгааг юуны түрүүнд хэлэхэд таатай байна. Компани санхүүгийн жилийн үзүүлэлтээрээ алдагдалтай гарсан нь өмнөх хугацааны баланс дээр нуугдмал байсан авлага, хугацаа хоцорсон өглөгүүдийг барагдуулсны үр дүн юм. Бид төлөх ёстой өр төлбөрүүдээ барагдуулж, найдваргүй авлагуудаа алдагдлаар хааж, боломжийн авлагыг барагдуулах, нөхцөл өөрчлөх зэрэг алхмуудыг авч ажиллалаа. Эрсдлийн удирдлага, засаглалын тогтолцоогоо бэхжүүлж, хөрөнгө, сангийн удирдлагын ажилд ахиц дэвшил гаргаж ирсэн болно.

2014 онд компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд орсон томоохон өөрчлөлт буюу ВенчерсУан, Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хооронд хийгдсэн арилжааг бүртгүүлэх ажил сунжирч, бидний ажилд нэлээдгүй саад бэрхшээл учирсан ч хамтын хүчээр энэ асуудлыг нааштай шийдвэрлэн хувьцаа эзэмшигчдийн дунд үүсээд байсан үл ойлголцлыг амжилттай даван туулж, цаашдын хамтын ажиллагааны үндэс суурийг тавьсан хүндхэн жилийг ардаа үдлээ. Оны эхний улиралд хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрэлдээгүйн

улмаас хуралдуулж чадаагүй боловч 2015 онд ТУЗ-ийн нийт 3 удаагийн ээлжит, нэг удаагийн ээлжит бус хурал хуралдаж, компанийн өмнө тулгараад байсан олон асуудлуудыг амжилттай шийдвэрлэсэн байна. Юуны өмнө ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Сүү ХК-ийн Гүйцэтгэх захирал Булганы Гантулгыг томилох асуудлыг ТУЗ-ийн Засаглал, урамшууллын хороогоор хэлэлцэн дэмжиж, ТУЗ бүрэн эрхийнхээ хүрээнд дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл түүнийг ТУЗ-ийн түр гишүүнээр томилсон болно. ТУЗ-ийн дэргэд байнгын хороодыг байгуулж, үүнд Аудитын Хороог албан ёсоор 3 хүний бүрэлдэхүүнтэй бий болгож, хорооны нарийн бичгийн даргыг мөн томилж, компанийн дотоод хяналт, үйл ажиллагаанд учирч болзошгүй аливаа эрсдлүүдийг цаг тухайд нь илрүүлэх үндсэн үүрэг бүхий Дотоод Аудитын Албыг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө, эрх хэмжээ, аудиторын цалин зэргийг Гүйцэтгэх албанаас бие даасан байдлаар тогтоож үйл ажиллагааг нь эхлүүлээ.

2015 оны 8 дугаар сард ТУЗ-ийн ээлжит хурлаас байгууллагын бүтэц, зарим хувьцаа эзэмшигчдийн хувьцаа худалдах тухай санал, компанийн дүрмийн санг 750 сая төгрөгөөр нэмэгдүүлэх тухай асуудлуудыг авч хэлэлцэн, ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томиллоо.

Цаг үеийн шаардлагын улмаас оны дундуур буюу 2015 оны 7 дугаар сард компанийн Гүйцэтгэх захирлаар А.Батболдыг томилж ажлыг нь хүлээлцүүлэв. Мөн 9 дүгээр сард хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТУЗ-ийн 7 гишүүнийг улируулан сонгож, гүйцэтгэх захирлын томилгоог баталгаажуулан гэрээ, гүйцэтгэлийн үзүүлэлт зэргийг батлан, компанийн дүрэмд хуульд

нийцүүлэн зайлшгүй хийх шаардлагатай хэд хэдэн чухал өөрчлөлтийг хийж чадсан. Бид 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг дахин зарлан хуралдуулж, дүрмийн санг нэмэгдүүлэх, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, хувьцаа эзэмшигчдийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шийдвэрийг амжилттай гаргалаа.

Компанийн Гүйцэтгэх захирлаар 7 жил ажилласан Давгабалжирын Чулуунцэцэг захиралдаа цаашдын ажилд нь өндөр амжилт хүсэхийн зэрэгцээ хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн түвшинд хамтран ажиллаж, компанийнхаа зах зээлд тэргүүлэх байр суурийг улам бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байгааг илэрхийлмээр байна. Шинээр томилогдсон захиралдаа ТУЗ болон хувьцаа эзэмшигчидтэйгээ ойр ажиллаж, тэдгээрийн саналыг үйл ажиллагаандаа байнга тусгаж ажиллахын хамтаар даатгуулагчдын эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, шилдэг үйлчилгээг үзүүлэгч, зах зээлд тэргүүлэгч даатгагч болох зорилтдоо ойрын хугацаанд хүрэхийн өлзийтэй ерөөлийг дэвшүүлье.

Оны эцсээр буюу 2015 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн ТУЗ-ийн хурлаас бид компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг баталж, Баянзүрх дүүрэгт Зүүн бүсийн төвийг сэргээн байгуулах шийдвэрийг тус тус гаргаж ажиллалаа. ТУЗ-ийн дэргэд Аудитын хорооноос гадна Засаглалын хороо, Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороодыг байгуулсан бөгөөд ирэх жилдээ хороод маань тус тусын хариуцсан ажилдаа ханцуй шамлан ороход бэлэн болсон байна.

2016 онд компани салбартаа тэргүүлэх хэмжээнд үзүүлэх тоон болон чанарын үзүүлэлтийг бид баталсан бөгөөд энэхүү зорилтод хүрэхийн тулд гүйцэтгэх удирдлагатайгаа нягт хамтран ажиллана. Үүний зэрэгцээ компанийн хамгийн том хувьцаа эзэмшигч Ард Санхүүгийн Нэгдэлийн зүгээс үзүүлэх дэмжлэг, түүний хараат болон охин компаниудын хамтын ажиллагаа, групп компаниудын хамтарч ажилладаг бусад сүлжээ, холбоод, хамтрагч байгууллагууд нь Ард Даатгалын үйл ажиллагаанд ихээхэн дэмжлэг үзүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулах нэмэлт суваг болж амжилтад хүрэхэд үлэмж түлхэц болно гэдэгт итгэлтэй байна.

Ингээд харилцагч, даатгуулагч, хамтрагч, хувьцаа эзэмшигч, ажилтан та бүгддээ аз жаргал хүсэн ерөөж, өөдлөн дэвжихийн өлзийтэй ерөөлийг өөд өөд нь өргөн дэвшүүлье.

Чулууны **ГАНХУЯГ**  
Хүчтэй. Хамтдаа!

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ



Ард Даатгал компанийн нийт даатгуулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчид, хамт олон та бүхэндээ Гал бичин жилдээ төрлөөрөө түвшин амгалан, элгээрээ энх амгалан байхын элзийтэй ерөөлийг дэвшүүлэн мэндчилье.

Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, дэлхий дахины санхүүгийн хямрал, түүхий эдийн үнийн уналт зэргээс хамааран 2015 он манай компанийн хувьд сорилт болсон, бидний чадал чансааг шалгасан жил болж өнгөрлөө гэж дүгнэж байна.

2015 онд бид ТУЗ-өөс баталсан төлөвлөгөөг 70 орчим хувийн биелэлттэй үлдээ. Эдийн засгийн есөлт өмнөх жилүүдтэй харьцуулбал огцом буурсан, инфляци 2 хувь орчим, төгрөгийн ханш 15-20 хувиар суларсан, гадаадын хөрөнгө оруулалт урьд өмнө байгаагүй түвшинд хүртлээ унасан хүндхэн жилийг бид амжилттай даван туулж, зах зээлийн хүнд нөхцөлд ч манай хамт олон өөрсдийн хүчин чадлыг бүрэн дайчлан, ажиллаж чаддаг гэдгийг харууллаа. 2015 онд компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл өөрийн хувийг 55.31 хувь хүртэл нэмэгдүүлж, давамгайл байдлтай хувьцаа эзэмшигч боллоо. Ард Санхүүгийн Нэгдэл нь банк санхүү, даатгал, хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг, хөрөнгө оруулагчдын хувьцааны үр өгөөжийг хамгийн өндөр түвшинд байлгах, санхүүгийн тэргүүлэгч групп болох зорилт тавин ажиллаж байгаа компани юм.

Өнгөрсөн жил манай компани нийт 9 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлж, 2 орчим тэрбум төгрөгийг давхар даатгалд төлж, 7 орчим тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлоготой ажиллалаа. 2015 онд бид 3.8 тэрбум төгрөгийг нөхөн төлбөрөөр олголоо. Эдгээр үзүүлэлтээр бид салбарын шилдэг 5 компанийн дотор багтаж ТОП 5 даатгагчийн нэг гэсэн байр сууриа баталгаажуулсан.

Гэвч бид эдгээр тоон үзүүлэлтээс гадна

чанарын бусад үзүүлэлтийг онцгойлон анхаарах шаардлага байна. Хохирлын харьцаа, зардлын харьцаа, мөн төлбөрийн чадварын үзүүлэлтээр бид өнөөгийн үзүүлэлтүүдээ сайжруулж бусдыгаа манлайлах хэрэгтэй байна. Эцэст нь бидний ажлыг дүгнэх хамгийн чухал үзүүлэлт болох ашгийн түвшинг өнөөдрийнхөөс хэд дахин нэмэгдүүлэх шаардлага байна.

Өнгөрсөн оны эцсээр бид 2016 оны төсвийг ТУЗ-өөр амжилттай батлуулж, уг төсвийн хүрээнд ажиллагсдынхаа цалинг тодорхой хувиар нэмсэн. Бүх ажиллагсдыг Ард Санхүүгийн нэгдлийн гишүүн байгууллага Ард Актив ХЗХ-ны тэтгэврийн сангийн үйлчилгээнд хамруулж, урт хугацаатай, тэтгэврийн хуримтлалд хамруулах шийдвэрийг 9 дүгээр сараас гаргаад хэрэгжүүлээд явж байна. Цаашид ажиллагсдын ажлын гүйцэтгэл, ажилласан жил зэргээс хамааран байгууллагаас тэтгэврийн хуримтлалд төлгөд хувийг нэмэгдүүлээд явах бодлогыг барина. Ажиллагсад маань Ардын гишүүн байгууллагуудаас хадгаламжаас гадна зээл санхүүгийн бусад үйлчилгээ авах боломж нээгдсэн.

Хөдөө орон нутаг аймаг сумдад бидний өмөг түшиг болж, компанийн нэр төрийг өндөрт өргөж яваа салбарын захирлуудаа оны эцсээр цуглуулж, шаардлагатай сургалт хийж, зөвлөгөө удирдамжаар ханган, бүрэн цэнэглээд орон нутагт нь илгээлээ. Салбарын хүмүүсийнхээ ур чадварыг дээшлүүлэх, мэргэжил мэдлэгийг нь байнга цэнэглэх, урам хайрлах, тухайн орон нутагт үйл ажиллагаагаа идэвхжүүлэх талаар компанийн төв албанаас байнга анхаарч, дэмжиж ажиллах хэрэгтэй байна. Орон нутагт бид зах зээлээ төлөх, борлуулалтаа нэмэх боломж бий. Оны эцсээр Баянзүрх дүүрэгт Зүүн бүсийн төвийг сэргээн байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлээ. Шинээр байгуулагдсан зүүн бүсийн төв, шинэ салбарын ажиллагсаддаа цаашдын ажлын их амжилт хүсэн ерөөе.

Даатгалын менежерүүд маань

борлуулалт хийхийн хажуугаар гэрээний чанарт анхаарч ажиллах шаардлагатай байна. Даатгалын бүтээгдэхүүн бүрээр шинжилгээ хийж, маркетинг, бүтээгдэхүүн түгээх суваг зэргийг нарийн бодолцон, шаардлагатай бол бүтээгдэхүүнийхээ нөхцлийг өөрчлөх, харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцүүлж уян хатан ажиллалал борлуулалтыг нэмэх боломжтой. Мөн даатгалын бусад бүтээгдэхүүнийг хөдөө орон нутаг дахь салбаруудаар түлхүү борлуулах хэрэгтэй байна. Даатгалын зуучлагч, брокеруудтай хамтарч ажиллах нь зайлшгүй боловч шимтгэл хураамжийн хувьд нэгдсэн бодлоготой байж, компанийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж гэрээний чанарт анхаарна. 2015 онд бид хашаа байшин, зээлийн даатгал, түрээслэгчийн хариуцлага, эмчийн хариуцлагын шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлсэн боловч бүтээгдэхүүн бүрээр хийсэн борлуулалтад дүн шинжилгээ хийж, борлуулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Санхүүгийн удирдлага, хяналтыг сайжруулж, тайлан гаргах, төсөв төлөвлөгөө боловсруулах ажил жигдэрч, санхүү мөнгөний бүхий л гүйлгээ түргэн шуурхай болсон. Цаашид санхүү удирдлагын газраас санхүүгийн сахилга батыг чангатгах, хөрөнгө эх үүсвэрийн удирдлагыг чанаржуулж компанийн төсөв, хөрөнгө, санхүүгийн гүйцэтгэлийг улам сайжруулах чиглэлд ажиллана.

Өнгөрсөн оны эхээр компанийн ТУЗ-өөс 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, УБ хотын А зэрэглэлийн бүст шинэ байр худалдан авах шийдвэрийг гаргасан.

Компанийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа програм хангамжийн найдвартай ажиллагааг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Гэвч бидний ажлыг хөнгөвчилсөн, тайлан мэдээ мэдээллийг хурдан шуурхай боловсруулдаг, хэрэглэгчдэд маш ойлгомжтой, орчин үеийн, хүчтэй, найдвартай програмын шийдэл бидэнд дутагдалтай хэвээр байгаа.

Саяхан болсон Даатгагчдын холбооны хурлаар манай компани холбооны удирдах зөвлөлд дахин сонгогдсон бөгөөд холбоогоор дамжуулан даатгалын салбарыг бүхэлд нь хөгжүүлэх, даатгалын компаниудын нийтлэг эрх ашгийг хамгаалах, олон нийтэд даатгалын ач холбогдлыг таниулах ажилд дахин хүчин зүтгэх болсныг дуулгая.

Ингээд бидний үнэнч харилцагч, даатгуулагч, хувьцаа эзэмшигч, хамтрагч түнш болон ажиллагсад та бүхэндээ 2015 оны санхүүгийн жилийн тайланг толилуулж байгааг хүлээн авна уу!

Арьяасүрэнгийн **БАТБОЛД**

## ЗАСАГЛАЛ, БҮТЭЦ



2014 оны сүүлээр Ард Даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь 55.31 хувьтай компанийн томоохон хувьцаа эзэмшигч болж, 2016 оны эхээр СЗХ-ноос холбогдох зөвшөөрлийг аван улсын бүртгэлд бүртгүүлээд байна.

ТУЗ-ийн даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх Захирал Ч.Ганхуяг ажиллаж байгаа ба ТУЗ-ийн хараат гишүүнээр Ц.Тогтохбаяр, Д.Чулуунцэцэг, Антони Хоброу нар, хараат бус гишүүнээр “Алтай Холдинг” группын дэд ерөнхийлөгч, “Чингис” зочид буудлын гүйцэтгэх захирал О.Одбаяр, “Сүү” ХК-ийн гүйцэтгэх Захирал Б.Гантулга нар тус тус томилогдсон. ТУЗ-д гүйцэтгэх удирдлагыг төлөөлөн А.Батболд ажиллаж байна. Компанийн ТУЗ-ийн гишүүд бүгд засаглалын сургалтад хамрагдаж, СЗХ-ны журам, зааварт тусгасан шаардлагуудыг бүрэн хангаж ажиллаж байна. 2015 онд Ард Даатгал ХХК нь компанийн засаглалын хувьд нэн чухал ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, аудитын хорооны журам зэргийг батлуулан мөрдөн ажиллаж байна. Үүнээс гадна ТУЗ-ийн дэргэд Засаглалын хороо, Аудитын хороо, Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороодыг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллаж эхэллээ.

2015 оны турш ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг 4 удаа, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2 удаа зарлан хуралдуулж, цаг үеийн болон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж ажилласан. 2015 оны 12 дугаар сард хуралдсан ТУЗ-ийн хурлаас компанийн бүтэц, 2016 оны төсөв, төлөвлөгөөг баталж, дүрмийн сан нэмэгдүүлэх, компанийн салбарыг байгуулах шийдвэрийг гаргасан.


### ТУЗ-ИЙН ХОРООД

**Аудитын хороо:** дарга Ц.Тогтохбаяр, гишүүд О.Одбаяр, Б.Гантулга, нарийн бичгийн дарга Э.Жавхланбаяр

**Засаглалын хороо:** гишүүд Ч.Ганхуяг, Д.Чулуунцэцэг, Антони Хоброу, нарийн бичгийн дарга Б.Чимгээ

**Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо:** дарга Ч.Ганхуяг, гишүүд Д.Чулуунцэцэг, Ц.Тогтохбаяр, А.Батболд, нарийн бичгийн дарга Г.Баярбат





**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**



ТУЗ-ийн дарга  
**Ч.ГАНХУЯГ**



ТУЗ-ийн гишүүн  
**Ц.ТОГТОХБАЯР**



ТУЗ-ийн гишүүн  
**А.ХОБРОУ**



ТУЗ-ийн гишүүн  
**Д. ЧУЛУУНЦЭЦЭГ**



ТУЗ-ийн гишүүн  
**О.ОДБАЯР**




ТУЗ-ийн гишүүн  
**Б.ГАНТУЛГА**



ТУЗ-ийн гишүүн  
**А.БАТБОЛД**

**КОМПАНИЙН БҮТЭЦ**



# 2015 ОНЫ САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2015 онд эдийн засгийн төлөв байдалд хэд хэдэн хүчин зүйл голлох нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байсан. Үүнд: Улс төрийн тогтвортой байдал, Оюу Толгойн далд уурхайн санхүүжилтийн асуудал болон бусад том төсөл, санхүүгийн салбарын нөхцөл байдал, гадаад орчин

Харамсалтай нь, дээрх хүчин зүйлсийн дийлэнх нь сөрөг үр дүнтэй байлаа. 2014 он улс төрийн тогтвортой байдлыг хадгалж чадаагүй нь хугацаа алдах, шийдвэр гарахгүй удах, санхүүжилт хийгдэхгүй байх зэрэг байдлаар бизнесийн салбарт сөрөг нөлөө үзүүлсэн.

Шинээр байгуулагдсан Засгийн газрын бүрэлдэхүүнд мөн л дахин өөрчлөлт орсон нь зах зээлийн болон хөрөнгө оруулагчийн итгэл сэргэхэд саад учруулсаар байна.

Том төслүүдээс Таван Толгойн төслийн хөрөнгө оруулалт шийдэгдэхгүй хойшилсон нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсэн, харин Оюу Толгойн далд уурхайн 2 дахь санхүүжилт шийдэгдэхээр болсон ч 2015 оны эдийн засагт нөлөөлөл үзүүлж амжихааргүй байлаа.

2016 онд хүлээгдэж буй хөрөнгө оруулалтын хэмжээ 18 тэрбум доллар байна. Эдгээр төсөл хөтөлбөрүүд шийдэгдэж, хөрөнгө оруулалт орж ирвэл 2016 оны эдийн засагт томоохон нөлөөллийг үзүүлэхээр байна. Тус төсөл хөтөлбөрүүдэд:


- Оюутолгойн 2 дахь санхүүжилт
- Таван Толгойн төсөл
- Таван Толгойн цахилгаан станц
- ТЭЦ 5
- Тэлмэнийн дулааны цахилгаан станц
- 1,167.6 км 9 замын төсөл
- Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төсөл
- Туул Сонгины усны нөөцийн цогцолборын төсөл гэх мэт хүлээгдэж буй төслүүд байна.

## МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Эдийн засгийн идэвхжил буурч, зээл олголт саарснаар зах зээл дэх мөнгөний нийлүүлэлтийн бууралт үргэлжилсээр байна. Тиймээс Монголбанкны зүгээс өнгөрсөн 12 дугаар сард бодлогын хүүг нэг нэгжээр бууруулан 12 хувь болгож 2016 оны 1 сараас хэрэгжиж эхэлсэн нь зах зээлийн идэвхжлийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлнэ. Дотоодын зээлийн өсөлт саарсан, гадаад цэвэр актив буурсан нь мөнгөний нийлүүлэлтийн бууралтад голлох нөлөөг үзүүлжээ.

Монголбанкны мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн зээл хуваарийн дагуу эргэн төлөгдөж байгаа, Хөгжлийн банкны санхүүжилт буурч байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг сааруулж буурахад нөлөөлжээ. Мөн зээлийн эрэлт болон нийлүүлэлт аль аль нь хумигдсан нь голлох нөлөө үзүүлжээ. Үүнээс үүдэн Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөл бодлогын хүүг бууруулсан нь цаашид хатуу мөнгөний бодлогыг сулруулж зах зээлийн идэвхжлийг сэргээх эерэг нөлөө үзүүлэхээр байна.

МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ




## ГАДААД ХУДАЛДАА

Засгийн газрын болон хувийн хэрэглээ буурснаар импортын хэмжээ буурч гадаад худалдааны ашиг 2014 онтой харьцуулахад 62 хувь өсчээ. Гадаад худалдааны тэнцэл 2014 онд 537.7 сая долларын ашигтай байсан бол 2015 оны эцэст 872.3 сая долларын ашигтай гарчээ. 2014 онтой харьцуулахад экспорт 1,104.8 сая доллар, импорт 1,439.0 сая доллараар буурч гадаад худалдааны эргэлт нийтдээ буурсан байна.

### ВАЛЮТЫН ХАНШ



Монголбанкны төгрөгийн доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2015 оны 12 дугаар сард 1,995.84 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6.0 хувь суларчээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалт бууралттай, гадаад валютын албан нөөцийн хэмжээ багассантай холбоотой төгрөгийн ханш сулрах дарамт үргэлжилж байна.



### ИНФЛЯЦИ

Дотоод эрэлт хумигдаж, хүнсний бүтээгдэхүүний үнэ буурсан нь улсын инфляцийн түвшинг нам доод түвшинд хүргэлээ.

2015 оны 12 дугаар сард жилийн инфляци улсын хэмжээнд 1.9 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 1.1 хувь болж буурчээ. Үүнд дотоод эрэлт хумигдаж, эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт багассан, импортын хэмжээ буурсан зэрэг нь голлох нөлөө үзүүлсэн.



# ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2015 онд ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, хөдөө аж ахуйн давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 34, даатгалын хохирол үнэлэгч 24 компаниуд тус тус даатгалын салбарт үйл ажиллагаа явуулсан байна.

№	МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГ	2011	2012	2013	2014	2015
1	Ердийн даатгалын компани	16	17	16	16	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1	1	1	1
3	Давхар даатгалын компани					1
4	Даатгалын төлөөлөгч	2057	2357	3187	3260	3314
5	Даатгалын зуучлагч	8	17	20	30	34
6	Даатгалын хохирол үнэлэгч	9	9	14	20	24
7	Актуарч	13	18	15	15	15

Ердийн даатгалын хувьд нийт 15 даатгалын компани, тэдгээрийн 255 салбар, 3314 төлөөлөгчид улс даяар даатгалын үйлчилгээ үзүүлсэн байна.


Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 133 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.4 хувиар буурсан байна. Энэ нь Моннис даатгал компани татан буугдсан, зарим томоохон даатгалын компаниудын хөрөнгө буурсан зэрэг нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нийт нөөц сан 65.3 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 хувиар буюу 2.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2015 онд 14 даатгалын хэлбэрээр 111 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг хуримтлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.8 тэрбум төгрөг буюу 3.6 хувиар өссөн байна.

2015 онд даатгалын зах зээлд нийт 35 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 4.2 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна. Нөхөн төлбөр олголтын харьцаа нь 0.51 хүрсэн нь өмнөх оноос 0.08 нэгжээр өссөн байна.

№	САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2014 Q4	2015 Q4	ӨӨРЧЛӨЛТ	
				ДҮН	ХУВЬ
1	Хураамжийн орлого	107,305.63	111,134.88	3,829.25	3.6%
2	Давхар даатгалын хураамж	31,556.24	41,932.66	10,376.42	32.9%
3	Даатгалын цэвэр хураамж	72,524.1	66,981.47	(5,542.64)	-7.6%
4	Орлогод тооцсон хураамж	71,476.22	66,981.47	(4,494.75)	-6.3%
5	Нөхөн төлбөр	30,860.59	35,146.98	4,286.39	13.9%
6	Хохиролын харьцаа	0.43	0.52	0.09	21.5%
7	Үйл ажиллагааны зардал	46,188.59	45,940.52	(248.07)	-0.5%
8	Тайлант үеийн цэвэр ашиг	1,987.44	4,258.28	2,270.84	114.3%
9	Нөөц сан	61,757.49	64,060.52	2,303.03	3.7%
10	Нийт хөрөнгө	146,025.07	133,831.87	(12,193.19)	-8.4%



# ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Ард Даатгал ХХК нь төв компанийн борлуулалтын менежерүүд болон нийт 24 салбар, 375 даатгалын төлөөлөгчдөөр дамжуулан иргэд, ААН-үүдийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн, уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүү, худалдааны салбаруудад санхүүгийн, эд хөрөнгийн, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын, гэнэтийн ослын гэх мэт даатгалын бүх төрлийн үйлчилгээг хүргэж ажиллалаа.

Орон нутгийн салбарууд даатгалын хураамжийн орлогоо тогтвортой нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх хувиа хадгалах зорилгоо амжилттай хэрэгжүүлэн ажилласан ба эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж салбарын ашигт ажиллагаа, зардлын үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч, Улаанбаатар хот болон зарим нэг аймагт салбараа татан буулгах, хүний нөөцийг дахин хуваарилах зэрэг арга хэмжээг авлаа.

2015 онд Ард Даатгал нь факультатив, трити давхар даатгалын төрлүүдээр Marsh, AIG, Allianz, UIB, ИНГОССТРАХ зэрэг давхар даатгагч болон брокеруудтай хамтарч ажиллалаа. Мөн AIG


болон Allianz компанийн Монгол дахь фронтинг даатгагч компаниар сонгогдон ажиллаж байна.

Тайлант онд 6,000 гаруй нөхөн төлбөрийн хохирлыг Монгол улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль, СЗХ-ын журам, заавар, даатгалын гэрээг үндэслэн барагдуулсан байна. Нийт нөхөн төлбөрийн тохиолдлын дийлэнхийг Жолоочийн хариуцлагын албан журмын болон Орон сууц эзэмшигчийн хариуцлагын даатгал эзэлж байна.


Бид иргэдийн даатгалын үйлчилгээнд түргэн шуурхай, чанартай, сэтгэл ханамжтай үйлчилгээ үзүүлэх энэхүү бодит шаардлагыг мэдэрч хохирлын дуудлага авах, бүртгэх, нөхөн төлбөр олголтын явцыг мэдээлэх, харилцагчийн санал гомдлыг хүлээн авах үйлчилгээний оператор ажилтны шинэ ажлын байр үүсгэж, АвтоСОС ХХК, хохирлын үнэлгээний байгууллагууд, авто засварын нэгдсэн сүлжээтэй хамтран ажиллах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.

**ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР**

2015 онд манай компани нийт 9.16 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн ба орлогын дийлэнх хувийг Хөрөнгийн даатгалын борлуулалт эзэлж байна. Бид 2015 онд 3.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлсөн ба нийт нөхөн төлбөрийн 45 хувийг Жолоочийн даатгал эзэлж байна.




2015 онд 15 даатгалын компани нийтдээ 111.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн ба бид даатгалын салбарын 8 хувийг бүрдүүлж, хамгийн их хураамжийн орлого төвлөрүүлсэн 5 даатгалын компанийн нэг болж чадлаа.




Манай компанийн төлсөн нөхөн төлбөрийн хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байна.



Даатгалын салбарын хэмжээнд 2015 онд даатгалын компаниуд нийт 35.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлсөн ба 11 хувийг Ард Даатгал ХХК олгожээ. Бид энэхүү үзүүлэлтээрээ мөн адил эхний 5 даатгалын компанийн нэг болсон.



- Ард Даатгал
- Бусад 14 даатгалын компани



- Ард Даатгал
- Бусад 14 даатгалын компани



Компанийн нийт хөрөнгийн хэмжээ жил ирэх тусам нэмэгдсээр 8.8 тэрбум төгрөгт хүрч даатгалын салбарын нийт хөрөнгө болох 133.8 тэрбум төгрөгийн 7 хувийг бүрдүүлсэн байна.



Компанийн нөөц сангийн хэмжээ жил ирэх тусам өссөөр 4.5 тэрбум төгрөгт хүрлээ.

# САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2015 оны эцэст компанийн нийт хөрөнгө 8,758.53 сая төгрөгт хүрч 2014 оны үзүүлэлттэй харьцуулбал 69.07 сая төгрөг буюу 1 хувиар өссөн байна.

2014 оны эцэст 4,163.41 сая төгрөгийн нөөц сангийн үлдэгдэлтэй байсан бол 2015 оны эцэст 4,531.62 сая төгрөг болж өссөн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 368.20 сая төгрөг буюу 9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт хураамжийн орлогын хувьд 9,159.63 сая төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2014 онд 3,095.30 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон бол 2015 оны эцэст 3,828.56 сая төгрөгийн нөхөн төлбөр олгож өмнөх оноос 733.26 сая төгрөг буюу 24 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөрөнгө оруулалтын орлого 580.46 сая төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх жилийн мөн үеэс 165 сая төгрөгөөр буурсан байна. Хөрөнгө оруулалтын орлого буурсан гол шалтгаан нь 2015 онд өөрсдийн оффис худалдаж авсантай холбоотой юм.

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	2014.12.31	2015.12.31
Даатгалын нийт хураамжийн орлого	10,106.26	9,159.63
Давхар даатгалын хураамж	1,816.25	1,841.97
Буцаасан даатгалын хураамж	94.66	239.05
Даатгалын цэвэр хураамжийн орлого	8,195.34	7,078.60
Нийт орлогод тооцсон хураамж	7,371.95	6,427.68
Нийт нөхөн төлбөр	3,095.30	3,828.56
Байгуулсан нөөц сан	1,707.99	1,906.07
Даатгалын хураамжийн бус орлогын дүн	749.62	668.84
Даатгалын орлого дүн	4,700.77	3,475.68
Үйл ажиллагааны зардлын дүн	4,360.62	3,854.23
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	340.15	(378.55)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн	35.96	222.64
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	376.11	(155.91)
Орлогын татварын зардал	62.36	58.05
Татварын дараах ашиг (алдагдал)	313.75	(213.95)

## ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР, ДАВХАР ДААТГАЛ (САЯ ТӨГ)

	2012	2013	2014	2015
Хураамж	8,520	10,094	10,106	9,160
Нөхөн төлбөр	1,761	2,557	3,095	3,829
Давхар даатгал	3,005	4,234	1,816	1,842

## НИЙТ ХӨРӨНГӨ & НӨӨЦ САН (САЯ ТӨГ)

	2012	2013	2014	2015
НИЙТ ХӨРӨНГӨ	6,345	7,128	8,689	8,759
НӨӨЦ САН	3,380	3,240	4,163	4,532

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	2014.12.31	2015.12.31	Өөрчлөлт	
			Дүн	%
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,961.55	4,917.54	(44.00)	-1%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	200.45	140.00	(60.45)	-30%
Авлага	2,390.09	1,754.18	(635.90)	-27%
Бараа материал	33.87	10.96	(22.90)	-68%
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	546.61	384.12	(162.50)	-30%
Эргэлтийн хөрөнгийн дүн	8,132.56	7,206.80	(925.76)	-11%
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө		1,411.71	1,411.71	100%
Бусад үндсэн хөрөнгө	421.07	308.64	(112.43)	-27%
Хуримтлагдсан элэгдэл	(164.17)	(168.63)	(4.46)	3%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	256.90	1,551.72	1,294.82	504%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,389.46</b>	<b>8,758.53</b>	<b>369.07</b>	<b>4%</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>				
Богино хугацаат өр төлбөрийн дүн	61.72	415.54	353.82	573%
Нөөц сангийн дүн	4,088.41	4,531.62	443.20	11%
Өр төлбөрийн нийт дүн	4,150.13	4,947.15	797.02	19%
Эзэмшигчдийн өмч	3,500.00	3,500.00	-	0%
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	739.33	311.37	(427.95)	-58%
Эзэмшигчдийн өмчийн дүн	4,239.33	3,811.37	(427.95)	-10%
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,389.46</b>	<b>8,758.53</b>	<b>369.07</b>	<b>4%</b>



# ХҮНИЙ НӨӨЦ

Ард Даатгал ХХК-ийн ололт амжилтын үндэс суурь нь чадвартай, мэргэжлийн ур чадвар бүхий, үнэнч шударга, өндөр бүтээмжтэй ажилтнууд юм.

2014 оны эцэст компани нийт 100 ажилтантай байсан бол 2015 оны эцэс гэхэд 98 ажилтантай ажлын байрыг хадгалсан амжилттай байна. Нийт ажилтнуудын 70 хувь нь даатгалын үйлчилгээг орон нутгийн 21 аймаг, нийслэлийн 3 салбараар дамжуулан даатгуулагч, харилцагчдад үзүүлж, 30 хувь нь төв албанд ажиллаж байна.

## ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2014	2015
Ажилтны тоо	100	98
Хотын болох орон нутгийн салбарууд	80%	70%
Төв албанд	20%	30%
Ажилтны хүйсийн харьцаа	эрэгтэй/эмэгтэй	
Салбарууд	40:60	34:66
Төв албанд	29:71	30:70
Ажилтнуудын дундаж нас	34-41	26-33

Компани нь ажиллах хүчний тоо хэмжээг өргөжүүлэхэд бус, хамт олны эгнээнд шинээр орсон болон тогтвортой ажиллаж буй нийт ажиллагсадныхаа мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор сургалтын хөтөлбөрийн дагуу ажилласан.

Компанийн нийт ажиллагсдыг тэтгэврийн сангийн үйлчилгээнд хамруулах бодлогын хүрээнд Ард Актив ХЗХ-той хамтран тэтгэврийн хуримтлалын үйлчилгээг эхлүүлж, компани ажилтан хоршоо гэсэн гурвалсан гэрээ байгуулан, ажиллагсдад урт хугацаатай хадгаламж, бага хүүтэй зээлийн үйлчилгээ авах боломжийг бий болголоо.

Улаанбаатар хотын нийт ажиллагсдыг "УБ Сонгдо" эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

Даатгагчдын баярыг угтсан даатгалын компаниудын спортын тэмцээнд багаараа амжилттай оролцож, ширээний теннисний төрөлд Алтан медаль авч тэргүүлээ.

Тайлант онд тэргүүний 3 ажилтан Санхүүгийн Зохицуулах Хорооны "Хүндэт Жуух Бичиг"-ээр, Монголын Даатгагчдын Холбооны "Оны шилдэг нөхөн төлбөрийн менежер"-ээр 1, "Оны шилдэг санхүүч"-ээр 1 ажилтан тус тус шалгарч шагнуулав.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ "ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ"



Санхүү Удирдлагын Газрын  
Захирал Т. Батцэнгэл



Даатгалын Ерөнхий  
Менежер Д. Баттулга



Шуурхай Дуудлагын  
Менежер Г. Алтансоёмбо

## МОНГОЛЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ ШАГНАЛ



"Оны шилдэг санхүүч"-ээр  
Санхүү Бүртгэлийн Албаны  
Дарга Д. Ангараг



"Оны шилдэг нөхөн төлбөрийн менежер"-ээр  
Нөхөн Төлбөрийн Менежер Б. Батцэцэг

# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Компани 2015 онд нийт улсын төсөвт 318 сая төгрөгийн татвар төлж, нийгмийн даатгалд 207 сая төгрөгийг хуримтлуулсан байна. Мөн нийт 15,4 сая төгрөгийг төр засгийн байгууллагууд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын нийгмийн төлөө үйлсэд хандив тусламж хэлбэрээр олгож хамтран ажиллалаа.



- Улаанбаатар хотын захын дүүргийн Дарь-Эх дахь "СОС-Хүүхдийн Хотхон" асрамжийн газрын хүүхдийн баяр болон шинэ жилийн баярын үйл ажиллагаанд оролцож, 250 хүүхдэд бэлэг өгч нэг өдрийг хамтдаа өнгөрүүллээ.



- Их Талын Дуулиан ТББ-аас Монгол орон даяар зохион байгуулагддаг "Дуулиан-2020" хүүхдийн футзалын тэмцээнд хотын захын Сонгинохайрхан дүүргийн 106, 107 дугаар сургуулийн хүүхдийн багийг ивээн тэтгэж дэмжин оролцлоо. Охидын 11 насны ангилалд 107 дугаар сургуулийн баг түрүүлж шилжин явах цом алтан медалиар, 13 насны ангилалд охидын 107 дугаар сургуулийн баг 3 дугаар байранд орж хүрэл медалиар тус тус шагнагдсан байна.



- Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын "Лучия Ди Ламмермур" дуурийн цоо шинэ уран бүтээлийг ивээн тэтгэж сонгодог урлагыг улсдаа хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ орууллаа.

- Жүдо бөхийн улсын шигшээ багийн гишүүн, Ард Санхүүгийн Нэгдлийн тамирчин О.Жавзмааг дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг тусалцаа үзүүлэн, ивээн тэтгэлээ.
- Оффроад автомашин сонирхогчдын клубтай хамтран Зэрлэг 4x4 бартаат замын уралдааны ерөнхий спонсорор оролцож, хамтран зохион байгууллаа.
- "Түлэгдэлтэй охинд туслах аян"-д хамт олноороо нэгдэн, сайн дурын хандив тусламж цуглуулж мөнгөн тусалцаа үзүүлсэн.



- ХБНГУ-ын Бюделсдорф хотноо зохион байгуулагдсан "NORD ART 2015 - Олон Улсын Дүрслэх Урлагийн Үзэсгэлэн"-гийн Монголын павильоны зохион байгуулалтыг ивээн тэтгэж, хамтран ажиллалаа. Тус үзэсгэлэнгийн үеэр 50 гаруй орны 250 уран бүтээлчийн бүтээлийг 80,000 гаруй үзэгчид үзэн танилцсан байна.
- Хөдөө орон нутгийн салбарын ажилтнууд маань Говь-Алтай, Говьсүмбэр, Сэлэнгэ аймгуудад зохиогдсон сургуулийн насны хүүхдэд замын хөдөлгөөний мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал олгох "Ногоон гэрэл - Цагаан шугам 2015" арга хэмжээг ивээн тэтгэж, идэвхтэй оролцлоо.

# АУДИТЫН ТАЙЛАН

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### "АРД ДААТГАЛ" ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

Санхүүгийн тайлангийн тухай

Бид "Ард Даатгал" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хавсаргасан Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон жилийн Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй ба бусад тайлбар мэдээллүүдэд аудит хийлээ.

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДАЙ ХОЛБООТОЙ УДИРДЛАГЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай Монгол Улсын хууль болон даатгалын багц дүрмийн дагуу бэлтгэж, шударгаар толилуулах, санхүүгийн тайлангуудыг алдаа юмуу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэх боломж бүрдүүлэхэд шаардагдах дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээдэг.

### АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах нь бидний үүрэг хариуцлага юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу явуулсан. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авахын тулд ёс зүйн шаардлагуудыг баримтлан, аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудит нь санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаарх аудитын нотолгоо олж авах зориулалтаар гүйцэтгэх горимуудыг багтаадаг. Сонгож авсан горимууд нь аудиторын үнэлэмжээс хамаарах бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ багтдаг. Эрсдэлийн энэхүү үнэлгээг хийхдээ аудитор аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг зохиох зорилготойгоор аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг өөртөө агуулдаг.

Бид аудитын дүгнэлтийн үндэслэл болохуйц зохистой бөгөөд хангалттай аудитын нотолгоог олж авсан гэж найдаж байна.

### АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь "Ард Даатгал" ХХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн тухай Монгол Улсын хууль, даатгалын багц дүрмийн дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

### БУСАД АСУУДАЛ

2015 оны 8 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Их Хуралаас Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай Монгол улсын хуулийг энэ хууль батлагдсан өдрөөс 2016 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хэрэгжүүлэхээр баталсан. Компани тайлант жилд энэ хуулийн хүрээнд хөрөнгө, орлого, энэ хуульд хамаарах бусад зүйлээ нөхөн тайлагнасан эсэхийг бид үнэлээгүй бөгөөд тайлант жилийн 4 дүгээр сарын 1 ба түүнээс өмнөх тайлант хугацаанд хамаарах аливаа залруулгын үндэслэлтэй байдлыг нотлоход зориулсан аливаа аудитын горим гүйцэтгээгүй болно.

### ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЛЭЭ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 95.1-р зүйлд заасан хэрэглэгчид болох "Ард Даатгал" ХХК-ийн хувь эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Огноо: 2016.04.15

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРМЫН ДАГАН МӨРДӨЛТИЙН  
ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН НЭМЭЛТ ДҮГНЭЛТ**

Хууль тогтоомж болон зохицуулалтын бусад шаардлагын даган мөрдөлтийн талаар

Бид “Ард даатгал” ХХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Даатгалын тухай хуулийн дагуу, Аудиторууд бид “Ард Даатгал” ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль, даатгалын багц дүрмийн даган мөрдсөн байдлыг авч үзсэн.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор даатгалын компанид мөрдүүлэхээр зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журмын мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд доорх зүйлээс бусад зүйлсийн хувьд Монгол Улсын хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

- Компани нь УБХНС -ийн тооцооллыг Санхүүгийн зохицуулах хорооны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д заасан аргачлалаар гүйцэтгэж, тооцооллын үр дүнг тайлант улирлын эцсээр нэмж байгуулах сан гэж үзэж байгуулсан байна.



Огноо: 2016 .04. 15

2015 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (мянган төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	2015 ОНЫ 12 САРЫН 31	2014 ОНЫ 12 САРЫН 31
Өмч, барилга, тоног төхөөрөмж	1,551,723	256,902
Урьдчилж төлсөн зардал	384,116	546,614
Бараа материал	10,961	33,865
Худалдааны ба бусад авлага	1,754,184	2,590,534
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө	140,000	-
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	4,917,542	4,961,545
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>8,758,526</b>	<b>8,389,460</b>

ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ

ӨР ТӨЛБӨР	2015 ОНЫ 12 САРЫН 31	2014 ОНЫ 12 САРЫН 31
Орлогд тооцоогүй хураамж	3,160,959	2,510,042
Учирч болзошгүй хохирлын нөөцийн сан	712,503	762,263
Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөцийн сан	658,155	816,109
Нэхэмжилсэн хохирлын нөөцийн сан	-	-
Давхар даатгалын өр төлбөр	284,867	-
Худалдааны ба бусад өр төлбөр	67,995	4,153
Орлогын татварын өр төлбөр	16,223	14,996
Бусад татвар шимтгэлийн өр	46,452	42,570
<b>ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>4,947,154</b>	<b>4,150,133</b>
<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
Дүрмийн сан	3,500,000	3,500,000
Хуримтлагдсан ашиг	311,372	739,327
<b>ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,811,372</b>	<b>4,239,327</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ</b>	<b>8,758,526</b>	<b>8,389,460</b>

2015 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛСОН ЖИЛИЙН  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	ДҮРМИЙН САН	ХУРИМТЛАГДСАН АШИГ	НИЙТ
<b>2013 ОНЫ 12 САРЫН 31</b>	<b>2,750,000</b>	<b>1,175,575</b>	<b>3,925,575</b>
Тайлант жилийн ашиг	-	313,752	313,752
Өмчид гарсан өөрчлөлт	750,000	(750,000)	-
<b>2014 ОНЫ 12 САРЫН 31</b>	<b>3,500,000</b>	<b>739,327</b>	<b>4,239,327</b>
Тайлант жилийн ашиг	-	(213,955)	(213,955)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
Олгосон ноогдол ашиг	-	(214,000)	(214,000)
<b>2015 ОНЫ 12 САРЫН 31</b>	<b>3,500,000</b>	<b>311,372</b>	<b>3,811,372</b>

\*Эдийн засгийн орчин нөхцөл, даатгалын компаниудын төлбөрийн чадварын байдлыг харгалзан дүрмийн сангийн хэмжээг 2015 онд нэмэгдүүлэх хугацааг 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдөр болгох тухай Санхүүгийн зохицуулах хорооны 445 дугаар тогтоол 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдөр гарсан.

## 2015 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛСОН ЖИЛИЙН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	2015 ОН	2014 ОН
Ердийн даатгалын хураамжийн орлого	9,159,627	9,806,255
Давхар даатгалын хураамж	(1,841,975)	(1,816,253)
Буцаасан даатгалын хураамж	(239,054)	(94,660)
<b>ДААТГАЛЫН ЦЭВЭР ХУРААМЖИЙН ОРЛОГО</b>	<b>7,078,598</b>	<b>7,895,342</b>
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн өөрчлөлт	650,916	523,391
<b>НИЙТ ОРЛОГОД ТООЦСОН ХУРААМЖ</b>	<b>6,427,682</b>	<b>7,371,951</b>
<b>НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР</b>	<b>(3,828,560)</b>	<b>(3,095,302)</b>
Үүнээс: УБНХНС -аас	(2,010,523)	(1,380,752)
УБХНС -аас	(103,263)	(1,741)
ОТХНТ -аас	(1,714,774)	(1,712,808)
Байгуулсан УБНХНС	(1,852,568)	(1,474,164)
ОТХ -аас байгуулсан НХНС	-	-
Байгуулсан УБХНС	(53,504)	(233,823)
<b>ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,806,836</b>	<b>3,951,156</b>
Ажиллагсадтай холбоотой зардал	(1,249,633)	(1,416,565)
Даатгалын гэрээний зардал	(1,390,184)	(1,283,992)
Ерөнхий удирдлагын зардал	(1,115,980)	(1,403,024)
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, (АЛДАГДАЛ)</b>	<b>(948,961)</b>	<b>(152,425)</b>
Санхүүгийн орлого/(зардал)	681,937	783,271
Бусад орлого, (зардал)	134,332	(245,425)
Бусад олз, (гарз)	(23,217)	(9,311)
<b>ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ</b>	<b>(155,909)</b>	<b>376,110</b>
Орлогын татварын зардал	(58,046)	(62,358)
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>(213,955)</b>	<b>313,752</b>

\* УБНХНС – Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан

\*\* УБХНС – Учирч болзошгүй хохирлын нөөц сан

\*\*\* ОТХ – Орлогод тооцсон хураамж

2015 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛСОН ЖИЛИЙН  
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2015 ОН	2014 ОН
Татварын өмнөх ашиг /(алдагдал)	(155,909)	376,110
Тохируулга:		
Элэгдэл, хорогдол	96,258	53,826
Үндсэн хөрөнгө худалдсаны олз (гарз)	21,819	9,311
Олгосон мөнгөн бус урамшуулал	8,375	-
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	(29,457)	439,247
Даатгалын хураамжийн авлагын өөрчлөлт	293,752	(1,338,769)
Бусад авлагын өөрчлөлт	485,386	(79,399)
Бусад татвар шимтгэлийн авлагын өөрчлөлт	214	30,249
Урьдчилж төлсөн зардал, тооцооны өөрчлөлт	162,498	(8,224)
Бараа материалын өөрчлөлт	22,904	(3,650)
Орлогд тооцоогүй хураамжийн өөрчлөлт	650,916	523,391
Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөцийн сангийн өөрчлөлт	(157,954)	93,411
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	(49,760)	232,081
Худалдааны ба бусад өглөгийн өөрчлөлт	58,444	(1,324)
Давхар даатгалын өглөгийн өөрчлөлт	284,867	-
Бусад татварын өөрчлөлт	3,882	42,570
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлт	1,755,149	(509,664)
	1,725,692	(70,417)
Төлсөн орлогын албан татвар	(56,818)	(24,859)
Хүүгийн орлого	(580,458)	(758,111)
Хүлээн авсан хүү	656,381	752,708
	19,105	(30,262)
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БИЙ БОЛСОН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>1,744,797</b>	<b>(100,679)</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(1,447,800)	(32,371)
Худалдан авсан хөрөнгө оруулалт	(140,000)	-
Хугацаа дуусгавар болсон санхүүгийн хөрөнгө	-	300,000
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,587,800)	267,629
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Гаргасан хувьцаат капитал	-	-
Хуваарилсан ноогдол ашиг	(214,000)	-
Хуримтлагдсан ашгаас дүрмийн санд оруулсан	-	-
Арилжааны банкнаас авсан зээл	13,000	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(201,000)	-
Тайлант жилд бий болсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(44,004)	166,950
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн оны эхний үлдэгдэл	4,961,545	4,794,595
<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛСИЙН ОНЫ ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>4,917,542</b>	<b>4,961,545</b>













WWW.ARDDAATGAL.MN



/ARDDAATGAL



@ARDDAATGAL



INFO@ARDDAATGAL.MN



7720-0088, 7720-0089

ХАЯГ: СИТИ ТАУЭР 502, 503 ТООТ, ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААНЫ НЭРЭМЖИТ ТАЛБАЙ,  
СҮХБААТАР ДҮҮРЭГ, УЛААНБААТАР-14200, МОНГОЛ УЛС